

Монголын Үнэт Цаасны Бирж ХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн
2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн
14 тоот тогтоолын хавсралт 2



ТООЦООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэр томъёоны тайлбар	3
НЭГ. Удиртгал	6
1.1. Зорилго.....	6
1.2. Хамрах хүрээ	6
1.3. Хүчин төгөлдөр байдал	6
ХОЁР. Төлбөр тооцоонд оролцогч.....	7
2.1. Төлбөр тооцоонд оролцогчдын төрөл	7
2.2. Төв клиринг, түүний үйл ажиллагаа	7
2.3. Тооцооны ерөнхий гишүүн, түүний үйл ажиллагаа	8
2.4. Тооцооны шууд гишүүн, түүний үйл ажиллагаа.....	9
2.5. Тооцооны эрхгүй гишүүн, түүний үйл ажиллагаа.....	10
2.6. Хадгаламжийн байгууллага	10
2.7. Төлбөрийн агент.....	11
2.8. Төлбөр гүйцэтгэгч банк.....	11
2.9. Харилцагч	12
ГУРАВ. Төв клирингийн гишүүнчлэл.....	13
3.1. Тооцооны гишүүний шалгуур үзүүлэлт	13
3.2. Тооцооны гишүүнээр элсэх өргөдөл гаргах.....	14
3.3. Тооцооны гишүүнээр элсүүлэх	14
3.4. Тооцооны гишүүнд тавих хяналт	15
3.5. Тооцооны гишүүний үүргээс чөлөөлөх	16
3.6. Бусад зохицуулалт.....	17
ДӨРӨВ. Клирингийн Данс.....	18
4.1. Клирингийн данс, түүний төрөл	18
4.2. Клирингийн дансны бүтэц	18
4.3. Клирингийн дансны бүртгэл.....	18
4.4. Бусад	18
ТАВ. Барьцаа ба дэнчин	19
5.1. Барьцаа.....	19
5.2. Дэнчин	19
5.3. Барьцаа болон дэнчингийн үнэлгээ	20
ЗУРГАА. Төлбөр тооцоо.....	21
6.1. Төлбөр тооцоо гүйцэтгэх үнэт цаас ба тооцооны аргачлал	21

6.2.	Хэлцэл хуваах, шилжүүлэх	21
6.3.	Хэлцэл баталгаажуулах	22
6.4.	Хэлцэл бүртгэх	23
6.5.	Эмхэтгэл.....	23
6.6.	Төлбөр гүйцэтгэх.....	24
ДОЛОО.	Бусад	25
7.1.	Клирингийн систем.....	25
7.2.	Мэдээ, мэдээлэл солилцох	25
7.3.	Шимтгэл, хураамж.....	26
7.4.	Гэрээний үүрэг биелүүлэхгүй байх буюу төлбөрийн чадваргүй болох	27
7.5.	Зөрчил, хариуцлага.....	28
7.6.	Маргаан шийдвэрлэх	29
7.7.	Давагдашгүй хүчин зүйл.....	30

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Энэ журам болон Төв клирингийн бусад хүчин төгөлдөр баримт бичигт заасан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

Төлбөр тооцооны үйл ажиллагаа

Тооцооны үйл ажиллагаа	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 43.1-т заасан үйл ажиллагаа
Төлбөрийн үйл ажиллагаа	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 44.1-т заасан үйл ажиллагаа
Төлбөр тооцооны үйл ажиллагаа	Үнэт цаасны тооцооны болон төлбөрийн цогц үйл ажиллагаа
Төлбөр тооцоонд оролцогч	Үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаанд оролцогч хувь хүн болон хуулийн этгээд

Төлбөр тооцоонд оролцогч

Төв клиринг	Монголын Үнэт Цаасны Биржийн бүтцээр батлагдсан Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын алба
Арилжаа эрхлэх байгууллага	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.28-д заасан хуулийн этгээд буюу бирж
Тооцооны эрхгүй гишүүн	Төв клирингээс тооцооны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл аваагүй, Биржийн гишүүн ҮЦК
Хадгаламжийн байгууллага	Үнэт цаасны бүртгэл, хадгалалт хариуцсан, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 45.1, эсхүл 46.1-д заасан үйл ажиллагаа явуулж буй этгээд
Төлбөрийн агент	Төв клиринг болон түүний гишүүний даалгаврын дагуу төлбөрийн үйл ажиллагаа гүйцэтгэх эрх бүхий этгээд
Төлбөр гүйцэтгэгч банк	Төв клирингтэй байгуулсан гэрээний үндсэн дээр Хорооны Үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагааны ерөнхий журмын 5.2-т заасны дагуу барьцааны мөнгөн хөрөнгө байршиж буй банк
Харилцагч	Биржийн гишүүн ҮЦК-д арилжааны данс нээлгэсэн хувь хүн, эсхүл хуулийн этгээд
Тооцооны гишүүн	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 43.2-т заасны дагуу тооцооны байгууллагатай гэрээ байгуулж, гишүүн болсон этгээдийг
Тооцооны ерөнхий гишүүн	Тооцооны эрхгүй гишүүнд тооцооны үйлчилгээ үзүүлэх эрхтэй тооцооны гишүүн
Тооцооны шууд гишүүн	Зөвхөн өөрийн болон харилцагчийнхаа тооцооны үйл ажиллагааг эрхлэх эрхтэй биржийн гишүүн ҮЦК

Данс

Клирингийн данс	Үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа явуулахад шаардлагатай, Төв клиринг дээр байршиж буй данс
Арилжааны данс	Үнэт цаасны хэлцэл бүртгэх клирингийн данс
Клирингийн дансны төвлөрсөн бүртгэл	Клирингийн дансны гүйлгээг өөрийн гишүүдээр нэгдсэн байдлаар бүртгэх Төв клирингийн бүртгэл
Клирингийн дансны тухайлсан бүртгэл	Клирингийн дансны гүйлгээг өөрийн харилцагч тус бүрээр бүртгэх тооцооны гишүүн, эсхүл тооцооны эрхгүй гишүүний бүртгэл

Барьцаа, дэнчин

Барьцаа	Төлбөр тооцооны үйл ажиллагааг хэвийн явуулах, төлбөрийн үүрэг биелүүлэх баталгаа болгож төлбөр тооцоонд оролцогчийн байршуулсан бэлэн мөнгө болон үнэт цаас
Дэнчин	Биржийн арилжааны хэлцлийн төлбөрийн үүргийг баталгаажуулахаар төлбөр тооцоонд оролцогчийн байршуулсан бэлэн мөнгө болон үнэт цаас
Барьцаа хүлээн авагч	Төлбөр тооцоонд оролцогчийн байршуулсан барьцааг хүлээн авч, түүний бүртгэлийг хөтөлж буй этгээд

Хэлцэл, позиц, төлбөр тооцоо

Хэлцэл	Төлбөр тооцоонд оролцогчид үнэт цаас солилцохоор харилцан тохиролцох
Биржийн хэлцэл	Төлбөр тооцоонд оролцогч хооронд биржээр арилжигдсан үнэт цаас худалдах, худалдан авах үүрэг
Биржийн бус хэлцэл	Төлбөр тооцоонд оролцогч биржийн бус зах зээл дээр үнэт цаас худалдах, худалдан авах үүрэг
Баталгаажсан хэлцэл	Төлбөр тооцоонд оролцогч өөрийн хийсэн хэлцлийн төлбөрийг төлж, хэлцлээр хүлээх бүх үүргээ хүлээх тухай баталгаажуулж буй мэдэгдэл
Биржид бүртгэлтэй үнэт цаас	Биржийн бүртгэлийн шалгуурыг хангаж, биржээр арилжигдахаар код авсан үнэт цаас
Биржид бүртгэлгүй үнэт цаас	Биржид бүртгэлтэй үнэт цааснаас бусад үнэт цаас
Позиц	Биржийн арилжаагаар худалдсан, эсхүл худалдан авсан нийт хэлцэл
Нээлттэй позиц	T+3 хүртэлх хугацаанд харилцагч төлбөрийн үүрэг барагдуулахаар хүлээгдэж буй позиц

Авах позиц	Биржийн арилжаагаар худалдан авах хэлцэл хийсэн позиц
Зарах позиц	Биржийн арилжаагаар худалдах хэлцэл хийсэн позиц
Эсрэг позиц	Авах позицын хувьд зарах, зарах позицын хувьд авах позиц
Репо хэлцэл	Үнэт цаас худалдах, буцаан худалдан авах хэлцэл
Төлбөр тооцоо хийх үнэ	Төв клиринг төлбөрийн үүрэг тодорхойлоход ашиглах үнэ
Жишиг үнэ	Төв клиринг үнэт цаасны үнэлгээ тооцоход ашиглах үнэ
Эмхтгэл	Төлбөрийн үүргийг тодорхойлох зорилгоор үнэт цаасны үнийн дүнг харилцан суутгаж балансжуулах
Төлбөрийн даалгавар	Үнэт цаасны буюу бэлэн мөнгөөр хийгдэх төлбөрийг гүйцэтгэх тухай мэдэгдэл
Клирингийн систем	Төлбөр тооцоонд оролцогчдын хоорондын төлбөр тооцооны үйл ажиллагааг зохион байгуулах зорилготой программ хангамж

Журам, гэрээ, бусад баримт бичиг

Төв клирингийн гишүүнчлэлийн гэрээ	Тооцооны гишүүн Төв клирингийн гишүүн хоорондын харилцааг зохицуулсан гэрээ
Клирингийн үйлчилгээ үзүүлэх гэрээ	Тооцооны ерөнхий гишүүн тооцооны эрхгүй гишүүнд төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх, тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулсан гэрээ
Үнэт цаас худалдах, буцаан худалдан авах гэрээ	Төлбөр тооцоонд оролцогчид төлбөрийн үүргээ барагдуулах зорилгоор үнэт цаасаа худалдаж, түүнийгээ хугацааны эцэст буцаан авах нөхцөлөөр байгуулж буй гэрээ
Үнэт цаасны зээлийн мастер гэрээ	Төлбөр тооцоонд оролцогчид үнэт цаас зээлэхэд ашиглах гэрээ

НЭГ. УДИРТГАЛ

1.1. Зорилго

- (1) Энэ журмын зорилго нь Төв клирингийн тооцооны үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлж, төлбөр тооцооны үйл ажиллагаанд оролцогчдын харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хамрах хүрээ

- (1) Энэхүү журмыг Төв клиринг болон түүний гишүүн (цаашид “тооцооны гишүүн” гэх), тэдгээрийн харилцагч (хамтад нь “төлбөр тооцоонд оролцогч” гэх) дагаж мөрдөнө.
- (2) Төв клиринг болон төлбөр тооцоонд оролцогчийн харилцан хүлээсэн эрх үүрэг нь энэ журмаас гадна дараах баримт бичгүүдээр тодорхойлогдоно. Үүнд:
 - (i) Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журам
 - (ii) Төлбөр тооцоонд оролцогч тус бүрт зориулсан клирингийн дансны бүртгэл хөтлөх заавар
 - (iii) Төлбөр тооцоонд оролцогчдын хооронд байгуулсан гэрээ
 - (iv) Төв клирингээс төлбөр тооцоонд оролцогчдын хоорондын харилцааг зохицуулахаар баталсан бусад.

1.3. Хүчин төгөлдөр байдал

- (1) Энэ журам, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх) батламжилна.
- (2) Хороо өөрөөр шийдвэрлээгүй бол энэ журам нь Хорооны тогтоолд заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөх бөгөөд журмыг мөрдөж эхлэхээс хуанлийн гуч (30)-аас доошгүй хоногийн өмнө Төв клирингийн цахим хуудсанд нийтлэн олон нийтэд танилцуулна.
- (3) Энэ журамтай нийцүүлэн гаргах Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журам болон бусад бичиг баримтуудыг Төв клиринг батална.
- (4) Энэ журмын хавсралтууд журмын салшгүй хэсэг байна.
- (5) Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын алба болон Төв клирингийн гүйцэтгэх удирдлага энэ журам болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад журам, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

ХОЁР. ТӨЛБӨР ТООЦООНД ОРОЛЦОГЧ

2.1. Төлбөр тооцоонд оролцогчдын төрөл

- (1) Төв клирингээс бусад төлбөр тооцоонд оролцогч нь түүний хэрэгжүүлэх үйл ажиллагаа, эрх үүргээс хамаарч дараах этгээд байна. Үүнд:
 - (i) Тооцооны гишүүн
 - (ii) Тооцооны эрхгүй гишүүн
 - (iii) Хадгаламжийн байгууллага
 - (iv) Төлбөрийн агент
 - (v) Төлбөр гүйцэтгэгч банк
 - (vi) Харилцагч
- (2) Төлбөр тооцоонд оролцогч тооцооны гишүүнийг тооцооны эрхгүй гишүүнд төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх эрхтэй эсэхээс хамаарч дараах төрөлд ангилна. Үүнд:
 - (i) Тооцооны ерөнхий гишүүн
 - (ii) Тооцооны шууд гишүүн
- (3) Төлбөр тооцоонд оролцогч хадгаламжийн байгууллагыг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйлчилгээ эрхлэх эсэхээс хамаарч дараах төрөлд ангилна. Үүнд:
 - (i) Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
 - (ii) Кастодиан

2.2. Төв клиринг, түүний үйл ажиллагаа

- (1) Төв клиринг нь Монголын Үнэт Цаасны Бирж ХК (цаашид “Бирж” гэх)-ийн ТУЗ-өөс баталсны дагуу Биржийн тухайлсан нэгж байх бөгөөд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу Хорооноос холбогдох тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.
- (2) Төв клиринг нь Үнэт цаасны зах зээлийн тухайн хуулийн 43.2-т заасны дагуу гишүүнчлэлтэй байх бөгөөд энэ журмын [Хавсралт 1](#)-д заасан загварыг ашиглан өөрийн гишүүдтэй гэрээ байгуулан ажиллана.
- (3) Төв клиринг нь Биржээр арилжигдсан болон арилжигдаагүй үнэт цаасны хэлцлийн бүртгэл, хэлцлийн хэрэгжилтийг хангуулах, эрсдэлийн удирдлагын арга хэрэгслүүдийг ашиглах, төлбөр тооцоонд оролцогч хоорондын төлбөрийн үүргийг тодорхойлох үндсэн чиг үүрэгтэй.
- (4) Төв клиринг нь энэ журмын 2.2(3)-т зааснаас гадна дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - (i) Төлбөр тооцоонд оролцогчийн үнэт цаасны болон бэлэн мөнгөний гүйлгээний бүртгэлийг хөтлөх;
 - (ii) Зах зээлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор төлбөр тооцоонд оролцогчоос дэнчин, барьцаа шаардах, төлбөрийн баталгааны болон эрсдэлийн сан үүсгэх, түүний бүртгэлийг хөтлөх;

- (iii) Төлбөр тооцоонд оролцогчийн барьцаа хөрөнгийн үнэлгээ хийх аргачлалыг тодорхойлох, үнэлгээ хийж, өдөр тутмын бүртгэл хөтлөх
 - (iv) Энэ журмын [Хавсралт 3](#)-т заасны дагуу тооцооны гишүүнээс үйлчилгээний хөлс, шимтгэл, хураамж тооцож нэхэмжлэх,
 - (v) Тооцооны гишүүн болон түүний харилцагчийн мэдээллийн сан үүсгэх, шаардлагатай тохиолдолд тухайн мэдээллийг ашиглах, тооцооны гишүүнээс нэмэлт мэдээлэл шаардах, гаргуулах;
 - (vi) Төлбөр тооцоонд оролцогчтой холбоотой мэдээ, мэдээллийг цаг тухайд нь хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд тайлбар өгөх;
 - (vii) Төлбөр тооцоонд оролцогчоос ирүүлсэн санал, гомдол, хүсэлтийг хүлээн авах, түүнийг шийдвэрлэх, тайлбар өгөх.
- (5) Төв клирингийн гүйцэтгэх үйл ажиллагаа, түүний эрх үүрэг нь энэ журмын 2.2(3), 2.2(4)-т зааснаар хязгаарлагдахгүй бөгөөд Төв клирингээс гаргасан бусад баримт бичигт заасан бол Төв клирингийн үйл ажиллагаа, эрх үүрэгт хамааруулан авч үзнэ.

2.3. Тооцооны ерөнхий гишүүн, түүний үйл ажиллагаа

- (1) Тооцооны ерөнхий гишүүн нь энэ журамд заасны дагуу хүсэлт гаргаж, Төв клирингтэй гишүүнчлэлийн гэрээ байгуулна.
- (2) Тооцооны ерөнхий гишүүн нь тооцооны эрхгүй гишүүнтэй энэ журмын [Хавсралт 2](#)-т заасан үлгэрчилсэн загварыг ашиглан гэрээ байгуулах бөгөөд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- (3) Тооцооны ерөнхий гишүүн нь өөрийн болон харилцагч тооцооны эрхгүй гишүүн, түүний харилцагчийн тооцоог Төв клирингээс ирүүлсний дагуу гүйцэтгэх, түүний бүртгэлийг хөтлөх, хэрэгжилтийг хангуулах зэрэг үндсэн чиг үүрэгтэй.
- (4) Тооцооны ерөнхий гишүүн энэ журмын 2.3(3)-т зааснаас гадна дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - (i) Төлбөр гүйцэтгэгч банктэй гэрээ байгуулж, төлбөр тооцоо гүйцэтгэхэд шаардлагатай харилцах данс нээлгэх;
 - (ii) Төлбөрийн агенттай гэрээ байгуулж, үнэт цаасны болон бэлэн мөнгөөр хийгдэх төлбөрийн даалгавар илгээх;
 - (iii) Төв клирингийн өмнө өөрийн харилцагчийн төлбөрийн үүргийг хүлээх;
 - (iv) Төв клирингийн өмнө хүлээсэн төлбөрийн үүргээ биелүүлэх зорилгоор үнэт цаас зээлэх болон репо хэлцэл хийх;
 - (v) Төв клирингээс шаардсаны дагуу барьцаа хөрөнгө, дэнчинг холбогдох журамд заасны дагуу байршуулах;
 - (vi) Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд заасны дагуу өөрийн харилцагчаас барьцаа хөрөнгө болон дэнчин шаардах;
 - (vii) Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд заасан цагийн хуваарь, нөхцөлийн дагуу төлбөр тооцооны үйл ажиллагаанд оролцох;
 - (viii) Өөрийн харилцагчийн үнэт цаасны болон бэлэн мөнгөөр хийгдсэн төлбөр тооцооны бүртгэлийг хөтлөх;

- (ix) Төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлсний дүнд өөрийн харилцагчаас үйлчилгээний хөлс, шимтгэл, хураамж тооцож нэхэмжлэх, түүнийг гаргуулах;
 - (x) Өөрийн харилцагчийн арилжаа, төлбөр тооцоотой холбоотой мэдээллийн нууцлалыг хангах;
 - (xi) Төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэдээллийг Төв клиринг, түүний системээс авах, тухайн мэдээллийн нууцлалыг хангах;
 - (xii) Төв клирингийн гишүүнчлэлийн шалгуурыг тогтмол хангаж ажиллах;
 - (xiii) Төв клирингийн төлбөр тооцооны үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлт гаргах, түүнийг шийдвэрлүүлэх;
 - (xiv) Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд зах зээлийн тогтвортой байдал, түүнд оролцогчдын эрх ашгийг хамгаалж ажиллах.
- (5) Тооцооны ерөнхий гишүүний гүйцэтгэх үйл ажиллагаа, түүний эрх үүрэг энэ журмын 2.3(3) болон 2.3(4)-т зааснаар хязгаарлагдахгүй бөгөөд Төв клирингээс гаргасан бусад баримт бичигт заасан бол түүнийг мөн Тооцооны ерөнхий гишүүний үйл ажиллагаа, эрх үүрэгт хамааруулан авч үзнэ.

2.4. Тооцооны шууд гишүүн, түүний үйл ажиллагаа

- (1) Тооцооны шууд гишүүн гэж энэ журамд заасны дагуу хүсэлт гаргаж, Төв клирингтэй гишүүнчлэлийн гэрээ байгуулж, зөвхөн өөрийн болон харилцагчийнхаа тооцоог хийх эрхтэй Биржийн гишүүн ҮЦК-ийг хэлнэ.
- (2) Тооцооны шууд гишүүн нь өөрийн харилцагчтай тооцооны болон зуучлалын үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллана.
- (3) Тооцооны шууд гишүүн нь өөрийн болон харилцагчийнхаа тооцоог Төв клирингээс ирүүлсний дагуу гүйцэтгэх, түүний бүртгэлийг хөтлөх, хэрэгжилтийг хангуулах үндсэн чиг үүрэгтэй.
- (4) Тооцооны шууд гишүүн нь энэ журмын 2.4(3)-т зааснаас гадна дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - (i) Төлбөр гүйцэтгэгчтэй банктэй гэрээ байгуулж, төлбөр тооцооны гүйцэтгэхэд шаардлагатай харилцах данс нээлгэх;
 - (ii) Төлбөрийн агенттай гэрээ байгуулж, үнэт цаасны болон бэлэн мөнгөөр хийгдэх төлбөрийн даалгавар илгээх;
 - (iii) Төв клирингийн өмнө өөрийн харилцагчийн төлбөрийн үүргийг хүлээх;
 - (iv) Төв клирингийн өмнө хүлээсэн төлбөрийн үүргээ биелүүлэх зорилгоор үнэт цаас зээлэх болон репо хэлцэл хийх;
 - (v) Төв клирингээс шаардсаны дагуу барьцаа хөрөнгө, дэнчинг холбогдох журамд заасны дагуу байршуулах;
 - (vi) Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд заасан бол өөрийн харилцагчаас барьцаа, дэнчин шаардах;
 - (vii) Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд заасан цагийн хуваарь, нөхцөлийн дагуу төлбөр тооцооны үйл ажиллагаанд оролцох;
 - (viii) Өөрийн болон харилцагчийнхаа үнэт цаасны болон бэлэн мөнгөөр хийгдсэн төлбөр тооцооны бүртгэлийг хөтлөх;

- (ix) Төв клирингийн гишүүнчлэлийн шалгуурыг тогтмол хангаж ажиллах;
 - (x) Өөрийн харилцагчийн арилжаа, төлбөр тооцоотой холбоотой мэдээллийн нууцлалыг хангах;
 - (xi) Төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэдээллийг Төв клиринг, түүний системээс гарган авах, тухайн мэдээллийн нууцлалыг хангах;
 - (xii) Төв клирингийн төлбөр тооцооны үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлт гаргах, шийдвэрлүүлэх.
- (5) Тооцооны шууд гишүүний гүйцэтгэх үйл ажиллагаа, түүний эрх үүрэг энэ журмын 2.4(3) болон 2.4(4)-т зааснаар хязгаарлагдахгүй бөгөөд Төв клирингээс гаргасан бусад баримт бичигт заасан бол түүнийг мөн Тооцооны шууд гишүүний үйл ажиллагаа, эрх үүрэгт хамааруулан авч үзнэ.

2.5. Тооцооны эрхгүй гишүүн, түүний үйл ажиллагаа

- (1) Тооцооны эрхгүй гишүүн гэж Төв клирингээс төлбөр тооцоо хийх эрх аваагүй, Төв клирингийн гишүүн Тооцооны ерөнхий гишүүнтэй клирингийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан Биржийн гишүүн ҮЦК-ийг хэлнэ.
- (2) Тооцооны эрхгүй гишүүн нь өөрийн болон харилцагчийнхаа төлбөр тооцоог Тооцооны ерөнхий гишүүнээр гүйцэтгүүлэх, өөрийн харилцагчийн төлбөрийн үүргийг Тооцооны ерөнхий гишүүний өмнө хангуулж ажиллах үндсэн чиг үүрэгтэй.
- (3) Тооцооны эрхгүй гишүүн нь энэ журмын 2.5(2)-т зааснаас гадна дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - (i) Тооцооны ерөнхий гишүүнээр өөрийн болон харилцагчийн тооцоог гүйцэтгүүлэхэд шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх;
 - (ii) Төв клирингийн өмнө өөрийн харилцагчийн төлбөрийн үүргийг хүлээх;
 - (iii) Төв клирингийн өмнө хүлээсэн төлбөрийн үүргээ биелүүлэх зорилгоор үнэт цаас зээлэх болон репо хэлцэл хийх;
 - (iv) Тооцооны ерөнхий гишүүн болон Төв клирингээс шаардсан барьцаа хөрөнгө, дэнчин зэргийг холбогдох дүрэм журамд заасны дагуу байршуулах;
 - (v) Өөрийн харилцагчийн төлбөр тооцоотой холбоотой хүсэлтийг Төв клиринг, эсхүл Тооцооны ерөнхий гишүүнд хүргүүлэх, түүнийг шийдвэрлүүлэх;
 - (vi) Хорооноос номиналь данс эзэмших зөвшөөрөл авсан тохиолдолд өөрийн харилцагчийн тооцооны үйл ажиллагааг гүйцэтгэх, түүний бүртгэлийг хөтлөх.
- (4) Тооцооны эрхгүй гишүүний гүйцэтгэх үйл ажиллагаа, түүний эрх үүрэг энэ журмын 2.5(2) болон 2.5(3)-т зааснаар хязгаарлагдахгүй бөгөөд Төв клирингээс гаргасан бусад баримт бичигт заасан бол түүнийг мөн тооцооны эрхгүй гишүүний үйл ажиллагаа, эрх үүрэгт хамааруулан авч үзнэ.

2.6. Хадгаламжийн байгууллага

- (1) Хадгаламжийн байгууллага гэж Төв клиринг болон түүний тооцооны гишүүд, номиналь данс эзэмших эрхтэй тооцооны эрхгүй гишүүнтэй гэрээ байгуулж, үнэт цаасны хадгалалт, бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг хэлнэ.

- (2) Хадгаламжийн байгууллага номиналь болон бенифициар данс ашиглан үнэт цаасны хадгалалт, бүртгэлийг хөтөлж болох бөгөөд энэ тухай Төв клирингтэй байгуулсан гэрээнд нарийвчлан тусгасан байна.
- (3) Хадгаламжийн байгууллага нь Төв клирингээс ирүүлсэн даалгаврын дагуу үнэт цаасны шилжилт хөдөлгөөнийг гүйцэтгэх, бүртгэх, төлбөр тооцоонд оролцогчийн дансанд гарсан үнэт цаасны өөрчлөлтийг Төв клирингэд мэдэгдэх үндсэн чиг үүрэгтэй.
- (4) Хадгаламжийн байгууллага нь энэ журмын 2.1(1)-ийн (iv)-т заасан төлбөрийн агентын үйл ажиллагааг мөн эрхэлж болно.
- (5) Хадгаламжийн байгууллагын үйл ажиллагаа, эрх үүрэг нь энэ журмын 2.6(3)-т зааснаар хязгаарлагдахгүй бөгөөд Төв клирингээс гаргасан бусад баримт бичигт заасан бол түүнийг мөн Хадгаламжийн байгууллагын үйл ажиллагаа, эрх үүрэгт хамааруулан авч үзнэ.

2.7. Төлбөрийн агент

- (1) Төлбөрийн агент гэж Төв клиринг болон түүний тооцооны гишүүн, номиналь данс эзэмших эрхтэй тооцооны эрхгүй гишүүнтэй гэрээ байгуулж, үнэт цаасны бэлэн мөнгөөр хийгдэх төлбөрийн гүйлгээг хийх эрхтэй хуулийн этгээд байна.
- (2) Төлбөрийн агент нь бэлэн мөнгөөр хийгдэх төлбөрийн гүйлгээг хийж, Төв клиринг, хадгаламжийн байгууллага болон холбогдох төлбөр тооцоонд оролцогчид мэдэгдэх үндсэн чиг үүрэгтэй.
- (3) Төлбөрийн агент нь төлбөр тооцоонд оролцогчийн төлбөрийн гүйлгээг хийх зорилгоор төгрөгийн харилцах данстай байна.
- (4) Төлбөрийн агентын үйл ажиллагаа, түүний эрх үүрэг энэ журмын 2.7(2) болон 2.7(3)-т зааснаар хязгаарлагдахгүй бөгөөд Төв клирингээс гаргасан бусад баримт бичигт заасан бол түүнийг мөн Төлбөрийн агентын үйл ажиллагаа, эрх үүрэгт хамааруулан авч үзнэ.

2.8. Төлбөр гүйцэтгэгч банк

- (1) Төлбөр гүйцэтгэгч банк гэж Төв клиринг болон түүний тооцооны гишүүдтэй гэрээ байгуулсан, Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд заасан барьцаа хөрөнгийн харилцах данс байршиж буй банкныг хэлнэ.
- (2) Төлбөр гүйцэтгэгч банк нь Төв клиринг болон тооцооны гишүүдийн хүсэлтээр үнэт цаасны арилжааны төлбөр тооцоо хийх харилцах данс нээх, гэрээгээр харилцан тохирсон бол ирүүлсэн даалгаврыг үндэслэн харилцах данснаас зарлагын гүйлгээ хийх үндсэн чиг үүрэгтэй.
- (3) Төлбөр гүйцэтгэгч нь энэ журмын 2.8(2)-т зааснаас гадна тооцооны гишүүнтэй үнэт цаас зээлэх болон репо хэлцэл хийх үйл ажиллагаа явуулж болно.
- (4) Төлбөр гүйцэтгэгч банкны үйл ажиллагаа, эрх үүрэг энэ журмын 2.8(2) болон 2.8(3)-т зааснаар хязгаарлагдахгүй бөгөөд Төв клирингээс гаргасан бусад баримт бичигт заасан бол түүнийг мөн Төлбөр гүйцэтгэгч банкны үйл ажиллагаа, эрх үүрэгт хамааруулан авч үзнэ.

2.9. Харилцагч

- (1) Харилцагч гэж Биржийн гишүүн ҮЦК-д арилжааны данс нээлгэсэн хувь хүн болон хуулийн этгээдийг хэлнэ.
- (2) Харилцагч дараах үндсэн чиг үүрэгтэй. Үүнд:
 - (i) Өөрийн үйлчлүүлдэг ҮЦК-аас ирүүлсэн хугацаа, нөхцөлийн дагуу үнэт цаасаар болон бэлэн мөнгөөр хийгдэх төлбөрөө шилжүүлэх;
 - (ii) Өөрийн үйлчлүүлдэг ҮЦК-аас үнэт цаас борлуулсны орлогоо авах;
 - (iii) Төлбөр тооцоотой холбоотой үйлчилгээний хөлс, шимтгэл, хураамжийг заасан хугацаанд өөрийн үйлчлүүлдэг ҮЦК-д төлөх.
- (3) Харилцагчийн үйл ажиллагаа, түүний эрх үүрэг энэ журмын 2.9(3)-т зааснаар хязгаарлагдахгүй бөгөөд Төв клирингээс гаргасан бусад баримт бичигт заасан бол түүнийг мөн Харилцагчийн үйл ажиллагаа, эрх үүрэгт хамааруулан авч үзнэ.

ГУРАВ. ТӨВ КЛИРИНГИЙН ГИШҮҮНЧЛЭЛ

3.1. Тооцооны гишүүний шалгуур үзүүлэлт

- (1) Тооцооны гишүүн болохоор хүсэлт гаргагч (цаашид “Хүсэлт гаргагч” гэх) нь энэ журамд заасны дагуу Төв клирингэд хүсэлт гаргана.
- (2) Төв клиринг нь энэ журмын 3.1(3), эсхүл 3.1(4)-т заасан шалгуур үзүүлэлтийг хүсэлт гаргагч хангаж байгаа эсэхийг тодорхойлохын тулд энэ журамд зааснаас бусад бичиг баримтыг шаардах эрхтэй бөгөөд хүсэлт гаргагч түүнийг гаргаж өгөх үүрэгтэй.
- (3) Тооцооны ерөнхий гишүүн болохоор хүсэлт гаргагч нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:
 - (i) Хуулийн дагуу бүртгүүлж, үйл ажиллагаа явуулж буй Монгол Улсын хуулийн этгээд байх;
 - (ii) Хорооны холбогдох журамд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн болон мөнгөн хөрөнгийн шалгуур хангасан байх;
 - (iii) Үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа гүйцэтгэх санхүүгийн, хүний нөөцийн болон техникийн чадамжтай байх;
 - (iv) Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө боловсруулж, түүнийгээ хэрэгжүүлэх чадамжтай байх;
 - (v) Төв клирингтэй гэрээ байгуулсан төлбөр гүйцэтгэгч банкинд харилцах данс нээлгэсэн байх;
 - (vi) Тооцооны ерөнхий гишүүн болсон тохиолдолд Эрсдэлийн сангийн журам болон бусад холбогдох баримт бичигт заасны дагуу байршуулах барьцаа хөрөнгө, дэнчин зэргийг заасан хугацаанд байршуулах чадамжтай байх.
- (4) Тооцооны шууд гишүүн болохоор хүсэлт гаргагч нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:
 - (i) Үнэт цаасны Биржийн гишүүнчлэлтэй брокер байх;
 - (ii) Хуулийн дагуу бүртгүүлж, үйл ажиллагаа явуулж буй Монгол Улсын хуулийн этгээд байх;
 - (iii) Хорооны холбогдох журамд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн болон мөнгөн хөрөнгийн шалгуурыг хангасан байх;
 - (iv) Үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа гүйцэтгэх санхүүгийн, хүний нөөцийн болон техникийн чадамжтай байх;
 - (v) Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө боловсруулж, түүнийгээ хэрэгжүүлэх чадамжтай байх;
 - (vi) Тооцооны шууд гишүүн болсон тохиолдолд Эрсдэлийн сангийн журам болон бусад холбогдох баримт бичигт заасны дагуу байршуулах барьцаа хөрөнгө, дэнчин зэргийг заасан хугацаанд байршуулах чадамжтай байх.
- (5) Тооцооны ерөнхий гишүүн нь энэ журмын 3.1(3), Тооцооны шууд гишүүн нь энэ журмын 3.1(4)-т заасан шалгуур үзүүлэлтийг Төв клирингтэй байгуулсан гэрээний хугацаанд тогтмол хангаж ажиллана.

3.2. Тооцооны гишүүнээр элсэх өргөдөл гаргах

- (1) Хүсэлт гаргагч нь [Хавсралт 4](#)-т заасан маягтын дагуу “Тооцооны гишүүнээр элсэх тухай хүсэлт” гаргах бөгөөд Төв клиринг тухайн хүсэлтийг хүлээн авч, дараах бичиг баримтыг бичгээр ирүүлэх тухай хүсэлт гаргагчид мэдэгдэнэ. Үүнд:
 - (i) Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
 - (ii) Улсын бүртгэлд бүртгэгдсэн дүрмийн хуулбар;
 - (iii) Тооцооны ерөнхий гишүүн бол 3 (гурав)-аас доошгүй жилээр Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө;
 - (iv) Эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан сүүлийн 3 (гурван) жилийн санхүүгийн тайлан;
 - (v) Хүсэлт гаргагчийн дотоод үйл ажиллагааг зохицуулсан журам, харилцагчтай байгуулах гэрээний төсөл;
 - (vi) Хувь нийлүүлсэн болон толгой, охин компанийн тухай мэдээлэл;
 - (vii) Төв клирингтэй харилцах ажлыг хариуцсан ажилтны тодорхойлолт, танилцуулга, анкет;
 - (viii) Санхүүгийн баримт бичигт гарын үсэгт зурах эрх бүхий этгээдийн гарын үсгийн баталгаа.
- (2) Төв клирингэд ирүүлсэн бичиг баримтад өөрчлөлт гарсан тохиолдолд хүсэлт гаргагч ажлын 3 хоногт багтан Төв клирингэд мэдэгдэнэ.
- (3) Хүсэлт гаргагч нь Төв клирингэд ирүүлэх бүх бичиг баримтыг монгол хэл дээр бэлтгэн ирүүлэх бөгөөд бичиг баримтын үнэн зөв байдлыг хариуцна.
- (4) Хүсэлт гаргагч энэ журмын 3.2(1)-т заасан бичиг баримтыг Төв клирингэд бүрэн хүлээлгэн өгснөөр Төв клиринг тухайн хүсэлт гаргагчийн хүсэлтийг шийдвэрлэх үйл ажиллагаа эхэлсэнд тооцно.

3.3. Тооцооны гишүүнээр элсүүлэх

- (1) Хүсэлт гаргагчийг тооцооны гишүүнээр элсүүлэх эсэх тухай шийдвэр гаргах хугацаанд Төв клирингээс энэ журмын 3.2(1)-т зааснаас бусад нэмэлт материал шаардаж болох бөгөөд хүсэлт гаргагч тухайн нэмэлт материалыг заасан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.
- (2) Хүсэлт гаргагчтай гэрээ байгуулах, гэрээний нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай шийдвэрийг Төв клирингийн санал дүгнэлтэд үндэслэн ТУЗ гаргана.
- (3) ТУЗ хүсэлт гаргагчийг тооцооны гишүүнээр элсүүлэх эсэх тухай шийдвэрийг ажлын 30 (гуч) хоногт багтаан гаргана. Шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн даргын шийдвэрээр энэ хугацааг ажлын 10 (арав) хоног хүртэл хугацаагаар 1 (нэг) удаа сунгаж болно.
- (4) ТУЗ шийдвэр гаргахдаа ашиг сонирхол, нэгдмэл сонирхол, хамаарал бүхий этгээд зэрэг хүчин зүйлийг харгалзах бөгөөд энэ журамд заасан бүх шаардлагыг хангасан нь хүсэлт гаргагчтай гэрээ байгуулах үндэслэл болохгүй.
- (5) ТУЗ-ийн шийдвэр нь эцсийн шийдвэр тул хүсэлт гаргагч уг шийдвэртэй холбоотойгоор санал, гомдол гаргах эрхгүй.

- (6) ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш ажлын 3 (гурав) хоногийн дотор Төв клиринг шийдвэрийг хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.
- (7) Тооцооны гишүүнээр элсүүлэхийг зөвшөөрсөн шийдвэр хүлээн авсан хүсэлт гаргагчтай гэрээ байгуулах ажлыг Төв клиринг зохион байгуулна.
- (8) Тооцооны гишүүнээр элсүүлэхээс татгалзсан шийдвэр хүлээн авсан хүсэлт гаргагч хуанлийн 6 (зургаа)-н сарын хугацаанд дахин тооцооны гишүүнээр элсэх хүсэлт гаргах эрхгүй.
- (9) Тооцооны гишүүний гэрээ байгуулсан хүсэлт гаргагч гишүүний кодоо авч, элсэлтийн хураамж төлөх хуваарийг тохирон Төв клирингийн систем суулгаж, түүнийг ашиглах эрх авснаар Төв клирингийн гишүүн болсон гэж үзнэ.
- (10) Төв клирингийн гишүүнчлэлийн элсэлтийн хураамж төлөх хуваарийг Төв клирингийн гишүүнчлэлийн гэрээний хавсралтаар оруулах бөгөөд элсэлтийн хураамж төлөх хуваарийг гэрээ байгуулснаас хойш 30 (гуч) хоногийн хугацаанд багтаж байхаар гэрээнд тусгана.
- (11) Тооцооны гишүүн энэ журмын [Хавсралт 3](#)-т заасан гишүүнчлэлийн элсэлтийн хураамжийг Төв клирингээс ирүүлсэн нэхэмжлэхэд заасан хугацаанд төлнө.
- (12) Тооцооны гишүүн гишүүний код авах, клирингийн системд холбогдох асуудлыг Биржийн Мэдээллийн технологийн албаны журамд заасны дагуу зохицуулна.

3.4. Тооцооны гишүүнд тавих хяналт

- (1) Төв клиринг нь тооцооны гишүүдтэй байгуулсан гэрээ болон холбогдох дүрэм журмын хүрээнд тогтмол хяналт тавьж ажиллана.
- (2) Төв клирингээс тооцооны гишүүнд тавих хяналтыг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ. Үүнд:
 - (i) Төлбөр тооцоотой холбоотой үйл ажиллагаа холбогдох хууль, журам, шийдвэрийн хүрээнд явагдаж байгаа эсэхийг клирингийн системээр дамжуулан бодит цагийн горимоор;
 - (ii) Төв клиринг болон нийтэд мэдээлэхээр үүрэг хүлээсэн аливаа мэдээ, тайланг холбогдох журам, гэрээгээр тогтоосон хуваарийн дагуу хянах;
 - (iii) Алдаатай, буруу мэдээлэл ирүүлсэн буюу олон нийтэд мэдээлсэн, төлбөр тооцооны үйл ажиллагаа холбогдох эрх зүйн баримт бичгийн хүрээнд явагдахгүй байна гэж үзсэн тухай бүр.
- (3) Энэ журам болон бусад холбогдох баримт бичигт заасан аливаа шаардлага, эрх үүргийн хэрэгжилттэй танилцах зорилгоор Төв клиринг шалгалт зохион байгуулж болно.
- (4) Төв клиринг шалгалт зохион байгуулах шийдвэр гаргасан бол энэ тухай албан бичигт шалгалтын удирдамжийг хавсарган шалгалт эхлэхээс ажлын 3 (гурав) хоногийн өмнө Тооцооны гишүүнд хүргүүлнэ.
- (5) Шалгалтын удирдамжийг хууль, тогтоомжийн дагуу боловсруулж, шалгалтын зорилго, хугацаа, хэлбэр, хамрах хүрээг тодорхой заасан байна.
- (6) Төв клиринг шалгалтын тайланг тооцооны гишүүн болон ТУЗ-д танилцуулах бөгөөд шалгалтын үр дүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлно.

3.5. Тооцооны гишүүний үүргээс чөлөөлөх

- (1) Тооцооны гишүүн өөрийн гишүүнчлэлийн хүрээнд хүлээсэн үүргээсээ чөлөөлөгдөх тухай хүсэлтээ 1 (нэг)-ээс доошгүй сарын өмнө Төв клирингэд мэдэгдэнэ. Тухайн тооцооны гишүүний үүргээс чөлөөлөгдөх хугацааг Төв клиринг тогтоох бөгөөд дараах хугацааны аль нэг байна. Үүнд:
 - (i) Төв клирингэд ирүүлсэн мэдэгдэлд заасан хугацаа;
 - (ii) Тооцооны гишүүн төлбөр тооцооны бүхий л үүргээ гүйцэтгэж, эсхүл шилжүүлж дууссан хугацаа.
- (2) Энэ журмын 3.5(1)-т заасны дагуу хүсэлт гаргасан тооцооны гишүүн өөрийн төлбөр тооцооны үүргийг бүрэн хэрэгжүүлж дууссан гэж Төв клиринг үзвэл дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - (i) Төлбөрийн үлдэгдэлтэй гарсан бол түүнтэй дүйцэх дүнгээр бэлэн мөнгө нэхэмжлэх;
 - (ii) Тооцооны гишүүний бэлэн мөнгөөр байршуулсан барьцаа хөрөнгийг буцаан шилжүүлэх;
 - (iii) Тооцооны гишүүн бэлэн мөнгөнөөс бусад хэлбэрээр байршуулсан барьцаа хөрөнгийг буцаан шилжүүлэх.
- (3) Тооцооны гишүүн үнэт цаасны төлбөр тооцоо хийх эрхээсээ хугацаагүйгээр чөлөөлөгдөх хүсэлт ирүүлсэн тохиолдолд түүнийг тооцооны гишүүнчлэлээ цуцлах хүсэлт гаргасан гэж ойлгоно.
- (4) Тооцооны гишүүн гишүүнчлэлээ цуцлах тухай хүсэлтийг 1 (нэг)-ээс доошгүй сарын өмнө Төв клирингэд бичгээр гаргана. Тооцооны гишүүний гишүүнчлэл дуусгавар болох хугацаа нь дараах хугацааны аль нэг байна. Үүнд:
 - (i) Төв клирингэд ирүүлсэн мэдэгдэлд заасан хугацаа;
 - (ii) Тооцооны гишүүн төлбөр тооцооны бүхий л үүрэг гүйцэтгэж дууссан, эсхүл шилжүүлж дууссан хугацаа.
- (5) Тооцооны гишүүний гишүүнчлэлийг цуцлахтай холбогдсон асуудлыг Төв клиринг хариуцах бөгөөд цуцлах тухай шийдвэрийг ТУЗ гаргана.
- (6) Тооцооны гишүүн гишүүнчлэлийн шаардлага хангахгүй болсон гэж Төв клиринг үзсэн бол түүний эрх, үүргийг хэсэгчлэн болон бүрэн түдгэлзүүлж болно.
- (7) Төв клиринг нь тооцооны гишүүний эрх, үүргийг түдгэлзүүлэх болсон тохиолдолд энэ тухай шийдвэр гарснаас хойш ажлын 3 (гурав) хоногт багтаан тооцооны гишүүнд мэдэгдэх үүрэгтэй.
- (8) Төв клиринг нь тооцооны гишүүний эрх, үүргийг түдгэлзүүлсэн тухай мэдэгдэхдээ түдгэлзүүлэх болсон шалтгаан, зөрчил илэрсэн бол түүнийг засах тухай шаардлага, шаардлагыг биелүүлэх хугацаа, биелүүлээгүй тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой заасан албан бичиг хүргүүлнэ.
- (9) Тооцооны гишүүн, эсхүл түүний харилцагч үнэт цаасны арилжааны гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүдэн гарсан зөрчлийг Эрсдэлийн сангийн журмаар нарийвчлан зохицуулна.

- (10) Тооцооны гишүүн үнэт цаасны арилжааны гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд учирсан хохирлыг арилгах хүртэл түүний Төв клирингэд байршуулсан аливаа хөрөнгийг буцаан олгохгүй байж болно.

3.6. Бусад зохицуулалт

- (1) Төв клирингийн гишүүнчлэлийг энэ журамд заасны дагуу олгох бөгөөд Төв клирингийн тооцооны гишүүний тоог хязгаарлаж болно. Энэ шийдвэрийг ТУЗ гаргана.
- (2) Төв клирингийн гишүүнчлэлийг энэ журмын 2.1(2)-т зааснаас бусад төрлөөр олгох тохиолдолд энэ тухай Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд заасан байна.
- (3) Төв клирингийн гишүүнчлэлтэй этгээд нь өөрийн болон түүний харилцагчийн нэр дээрх бүхий л төлбөрийн үүргийг Төв клирингийн өмнө хангах үүрэг хүлээнэ.

ДӨРӨВ. КЛИРИНГИЙН ДАНС

4.1. Клирингийн данс, түүний төрөл

- (1) Төв клиринг нь нийт төлбөр тооцоонд оролцогч хоорондын тооцоо хийх, тэдгээрийн хоорондын төлбөрийн үүргийг тодорхойлох зорилгоор төлбөр тооцоонд оролцогчийн ашиглах клирингийн данс, түүний бүтэц, хэлбэр зэргийг тодорхойлно.
- (2) Клирингийн данс, түүний бүтэц, хэлбэр зэргийг Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд тусгана.

4.2. Клирингийн дансны бүтэц

- (1) Төв клиринг клирингийн дансны бүтэц, түүнийг ашиглах этгээдийг үнэт цаас тус бүрээр нарийвчлан тогтоох бөгөөд энэ тухай Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд заасан байна.

4.3. Клирингийн дансны бүртгэл

- (1) Клирингийн дансны бүртгэлийг төвлөрсөн болон тухайлсан гэсэн үндсэн 2 (хоёр) хэлбэрээр хөтөлж болно.
- (2) Клирингийн дансны төвлөрсөн бүртгэлийг Төв клиринг хөтлөх бөгөөд Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журам, эсхүл Клирингийн дансны бүртгэл хөтлөх зааварт дансны бүртгэл хөтлөх аргачлалыг нарийвчлан тусгасан байна.
- (3) Тооцооны гишүүн өөрийн болон түүний харилцагч тооцооны эрхгүй гишүүний клирингийн дансны тухайлсан бүртгэлийг хөтлөх бөгөөд Төв клирингээс гаргасан Клирингийн дансны бүртгэл хөтлөх зааврыг дагаж мөрдөнө.

4.4. Бусад

- (1) Төлбөр тооцоонд оролцогч нь клирингийн дансанд хийгдсэн үнэт цаасны гүйлгээг хийх зорилгоор хадгаламжийн байгууллагад үнэт цаасны данс нээлгэнэ.
- (2) Төлбөр тооцоонд оролцогч нь клирингийн дансны бэлэн мөнгөөр хийгдэх төлбөрийг хүлээх авах зорилгоор төлбөр гүйцэтгэгч банкинд клирингийн дансны төрөл тус бүрээр, эсхүл нэгдсэн нэг харилцах данс нээлгэнэ.
- (3) Төлбөр гүйцэтгэгч банк дахь харилцах данс нь байгууллагын аж ахуйн данснаас салангид, зөвхөн төлбөр тооцооны дүнд үүссэн төлбөрийн үүргийг хүлээн авах, шилжүүлэх төгрөгийн харилцах данс байна.

ТАВ. БАРЬЦАА БА ДЭНЧИН

5.1. Барьцаа

- (1) Төв клиринг нь төлбөр тооцооны үйл ажиллагааг хэвийн зохион байгуулах, төлбөр тооцоонд оролцогч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тооцооны гишүүн болон тооцооны эрхгүй гишүүнээс барьцаа авч, түүний доод үлдэгдлийг тогтмол хангуулах үүрэгтэй.
- (2) Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд өөрөөр заагаагүй бол барьцааг тооцооны гишүүн нь Төв клирингэд, тооцооны эрхгүй гишүүн нь Тооцооны ерөнхий гишүүнд тус тус байршуулна.
- (3) Төв клирингэд байршуулах барьцааг Төв клирингээс ирүүлсэн нэхэмжлэхэд заасан хугацаанд Төв клирингийн дансанд байршуулна.
- (4) Барьцааг мөнгөн болон мөнгөн бус хөрөнгөөр байршуулж болно. Барьцаатай холбоотой дараах тооцооллыг төлбөр тооцоонд оролцогч тус бүрээр Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд тусгана. Үүнд:
 - (i) Шаардлагатай барьцааны доод хувь, эсвэл хэмжээ;
 - (ii) Барьцаанд заавал байршуулах мөнгөн хөрөнгийн доод хэмжээ, эсвэл хувь;
 - (iii) Барьцаанд байршуулж болох бусад хөрөнгийн жагсаалт;
 - (iv) Барьцаа хөрөнгийн үнэлгээг тооцох аргачлал.
- (5) Барьцаа хөрөнгийн гүйлгээний бүртгэлийг хэрхэн хөтлөх тухай Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журам болон Клирингийн дансны бүртгэл хөтлөх зааварт нарийвчлан тусгасан байна.
- (6) Төлбөр тооцоонд оролцогч нь барьцаа хөрөнгөө чөлөөлөх, эсхүл сул хөрөнгийг буцаан авах хүсэлт гаргасан тохиолдолд Төв клиринг түүнийг Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журмыг баримтлан шийдвэрлэнэ.
- (7) Төв клирингээс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд төлбөрийн үүргийн эрсдэлийг хаах зорилгоор тооцооны гишүүнээс нэмж барьцаа хөрөнгө байршуулахыг хэдийд ч шаардаж болно. Ингэхдээ Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд зааснаас өөр үнэлгээний аргачлал ашиглаж болно.
- (8) Төв клирингийн холбогдох дүрэм, журамд зааснаас гадна онцгой нөхцөл байдал үүссэн бол Төв клиринг холбогдох журамд зааснаас өөр хэлбэр, нөхцөлөөр барьцаа хөрөнгө шаардаж болно.
- (9) Тооцооны гишүүн, эсхүл тооцооны эрхгүй гишүүн нь түүний байршуулах аливаа барьцаа хөрөнгө зөвхөн түүний бүрэн өмчлөлийнх байх нөхцөлийг хангана.
- (10) Тооцооны гишүүн, эсхүл тооцооны эрхгүй гишүүнээс бусад этгээдийн нэр дээрх аливаа хөрөнгийг барьцаа хөрөнгөд бүртгэхгүй.
- (11) Бэлэн мөнгөнөөс бусад хэлбэрээр байршуулсан барьцаа хөрөнгийн бүртгэлийг хөтлөх зорилгоор Төв клиринг үйлчилгээний хөлс, шимтгэл, хураамж авч болно.

5.2. Дэнчин

- (1) Төлбөр тооцоонд оролцогчийн төлбөрийн үүргийг баталгаажуулах, зах зээлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор төлбөр тооцоонд оролцогч дэнчин байршуулна.

- (2) Төлбөр тооцоонд оролцогч дэнчинг Төв клирингийн дэнчингийн дансанд байршуулах бөгөөд байршуулах хэмжээг үнэт цаас бүрээр тооцож гаргасан байна.
- (3) Дэнчин байршуулах, дэнчин нэмэгдүүлэх, түүнийг тусгаарлах, дэнчин буцаан олгохтой холбогдсон харилцааг Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журмаар зохицуулна.
- (4) Дэнчинг үнэт цаасны үнийн өөрчлөлтийн түүхэн өгөгдөл нормал бус тархалттай бол нормал бус тархалттай тоон загвараар, нормал тархалттай бол VaR (Value at Risk) болон олон хугацаат загвараар тооцно. Дэнчинг эдгээр загвар тус бүрээр тооцож хамгийн бага алдаатай загварыг сонгон дэнчингийн хэмжээг тогтооно.
- (5) Дэнчингийн хувь, хэмжээ өөрчлөгдсөн тухай бүрт Төв клиринг нийт зах зээлд оролцогчдод нэн даруй мэдэгдэх бөгөөд мэдэгдэлд тухайн хувь, хэмжээг мөрдөж эхлэх хугацааг тодорхой заасан байна.
- (6) Төв клирингийн холбогдох дүрэм, журамд зааснаас гадна зах зээлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Төв клиринг нь төлбөр тооцоонд оролцогчдод урьдчилан мэдэгдэлгүйгээр дэнчингийн хувь, хэмжээг өөрчлөх, мөрдүүлэх эрхтэй.
- (7) Дэнчингийн хувь, хэмжээ өөрчлөгдсөнтэй холбоотойгоор нэмж байршуулах хөрөнгийг Төв клирингээс ирүүлсэн мэдэгдэл, түүнд нарийвчлан заагаагүй бол Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд заасны дагуу байршуулна.

5.3. Барьцаа болон дэнчингийн үнэлгээ

- (1) Төв клиринг энэ журам болон бусад холбогдох дүрэм, журам, зааварт заасны дагуу байршуулсан дэнчин болон барьцаа хөрөнгийн үнэлгээг хийх зорилгоор жишиг үнэ тооцож гаргана.
- (2) Дэнчин болон барьцаа хөрөнгийн үнэлгээ хийх жишиг үнийг Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд заасан аргачлалаар тооцно.
- (3) Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд өөрөөр заагаагүй бол Төв клирингийн тооцож гаргасан жишиг үнэ нь төлбөр тооцоонд оролцогчийн хувьд заавал дагаж мөрдөх үнэ байна.
- (4) Төв клирингээс албан ёсоор зарлаж гаргаагүй, аливаа гуравдагч этгээдийн гаргасан жишиг үнийн бодит байдалд Төв клиринг хариуцлага хүлээхгүй.

ЗУРГАА. ТӨЛБӨР ТООЦОО

6.1. Төлбөр тооцоо гүйцэтгэх үнэт цаас ба тооцооны аргачлал

- (1) Төв клиринг нь Үнэт цаасны зах зээлийн тухайн хуулийн 5.1-д заасан үнэт цаасны тооцооны үйл ажиллагааг гүйцэтгэх эрхтэй бөгөөд тухайн үнэт цаас нь Биржийн болон Биржийн бус хэлцлээр арилжигдсан байж болно.
- (2) Төв клиринг төлбөр тооцоо гүйцэтгэх үнэт цаасны жагсаалтыг өөрийн цахим хуудсанд байршуулах бөгөөд жагсаалтад өөрчлөлт орсон даруйд цахим хуудас дахь жагсаалтыг шинэчилнэ.
- (3) Төв клиринг дараах тохиолдолд тухайн үнэт цаасны төлбөр тооцоог гүйцэтгэх боломжгүй гэж үзэн тухайн хэлцлийг бүртгэх, түүнчлэн төлбөр тооцоо гүйцэтгэхээс татгалзаж болно. Үүнд:
 - (i) Тухайн үнэт цаасыг Биржээр арилжихыг түр зогсоосон буюу хориглосон бол;
 - (ii) Тухайн үнэт цаасны хөрвөх чадвар хангалтгүй гэж Төв клиринг үзсэн бол;
 - (iii) Тухайн үнэт цаасны гүйлгээний хэмжээ хангалттай хэмжээнд хүрээгүй гэж Төв клиринг үзсэн бол;
 - (iv) Тухайн үнэт цаасны нэг ч эзэмшигч Монгол Улсын иргэн буюу хуулийн этгээд биш болсон бол;
 - (v) Тухайн үнэт цаасыг бүртгэж, хадгалж буй хадгаламжийн байгууллага үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон гэж Төв клиринг үзсэн бол;
 - (vi) Тухайн үнэт цаасны төлбөр тооцоог цаашид гүйцэтгэх боломжгүй гэж Төв клиринг тодорхойлсон бол.
- (4) Үнэт цаасны төлбөр тооцоог дараах дараалал, цаг хугацааны дагуу гүйцэтгэнэ.
 - (i) Т+0 өдөр:
 - i. хэлцэл хуваах, шилжүүлэх хүсэлт авах, гүйцэтгэх;
 - ii. нийт оролцогчийн хэлцлийг баталгаажуулах;
 - iii. баталгаажуулсан хэлцлийг бүртгэж, оролцогчид мэдээлэх;
 - iv. баталгаажсан хэлцлийг эмхтгэх
 - v. нэхэмжлэх, төлбөрийн даалгавар боловсруулах, оролцогчид мэдэгдэх.
 - (ii) Т+1 - Т+3 өдөр:
 - i. Дээрх хугацааны нийт хэлцлийг эмхтгэх;
 - ii. Төлбөр гүйцэтгэх (төлбөрийн эсрэг нийлүүлэлт хийх)

6.2. Хэлцэл хуваах, шилжүүлэх

- (1) Төлбөр тооцоонд оролцогч өөрийн хийсэн хэлцлийг баталгаажуулахаас өмнө тухайн хэлцлийг хуваах, эсхүл шилжүүлэх хүсэлт гаргаж болно.

- (2) Хэлцэл хийсэн төлбөр тооцоонд оролцогч өөрийн хийсэн хэлцлийг хэд хэдэн хэлцэл болгон хувааж болох бөгөөд хэлцэл хуваах хамгийн бага нэгж нь тухайн үнэт цаасны нэг лоттой тэнцүү байна.
- (3) Хэлцэл хийсэн төлбөр тооцоонд оролцогч тухайн хэлцлийг бүтнээр нь, эсвэл хэсэгчлэн шилжүүлж болох бөгөөд клирингийн системд хэлцлийг хуваах болон шилжүүлэх үйлдлийг зөвхөн Биржийн гишүүн ҮЦК хийх эрхтэй.
- (4) Биржийн гишүүн ҮЦК нь зөвхөн өөрийн харилцагчдын хооронд хэлцэл шилжүүлэх үйлдлийг клирингийн системд хийж болох бөгөөд хоёр өөр ҮЦК-ийн хооронд хэлцэл шилжүүлэх тохиолдолд Төв клирингэд хүсэлт гаргаж, шийдвэрлүүлнэ.
- (5) Биржийн гишүүн ҮЦК нь хэлцэл шилжүүлэх үйлдлийг клирингийн системд гүйцэтгэсэн тохиолдолд тухайн хэлцлийг хийсэн болон түүнийг хүлээн авч буй этгээдүүд харилцан тохиролцсон, хэлцлийн үүрэг мөн шилжсэнд тооцно.
- (6) Хэлцэл шилжүүлсэн үед түүнийг хүлээн авч буй этгээдийн барьцаа хөрөнгө шаардлагатай хэмжээнд хүрэхгүй тохиолдолд Төв клиринг тухайн шилжүүлгийг цуцлах эрхтэй.
- (7) Хэлцэл шилжүүлэх үйлдэл нь үнэт цаасны төрлөөс хамаарч харилцан адилгүй байж болох бөгөөд энэ тухай Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд нарийвчлан тусгана.

6.3. Хэлцэл баталгаажуулах

- (1) Энэ журмын 6.1(1)-д заасан үнэт цаасны хэлцэл нь төлбөр тооцоонд оролцогчдын хооронд хийгдсэн хэлцэл байна.
- (2) Холбогдох талууд хэлцэл баталгаажуулсан нь Төв клиринг тухайн хэлцлийг хүлээн авч, төлбөр тооцоо гүйцэтгэх үндэслэл болно.
- (3) Хэлцэл баталгаажуулах холбогдох талыг хэрхэн тодорхойлох тухай Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд тусгана.
- (4) Хэлцэл баталгаажуулах хэлбэр, хугацаа, түүнийг баталгаажуулах этгээд, баталгаажсан хэлцлийн хэлбэр, түүнд агуулагдах мэдээлэл, хэлцлийн жагсаалт нь үнэт цаасны төрөл, төлбөр тооцоонд оролцогч, Биржийн арилжаа эсэхээс хамаарч харилцан адилгүй байж болох бөгөөд энэ тухай Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд нарийвчлан тусгана.
- (5) Хэлцэл баталгаажуулах хугацаанд төлбөр тооцоонд оролцогч ямар нэг хүсэлт Төв клирингэд ирүүлээгүй тохиолдолд тухайн хэлцлийг хүлээн зөвшөөрч, түүнтэй холбогдон гарах бүхий л төлбөр тооцооны үүргийг бүрэн хүлээсэнд тооцно.
- (6) Хэлцлийг холбогдох журамд заасны дагуу баталгаажуулаагүй нь талууд хэлцэлтэй холбогдон үүсэх эрх, үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- (7) Биржийн арилжааны хэлцэл баталгаажуулах явцад тооцооны эрхгүй гишүүн нь тухайн хэлцлийн төлбөр тооцоог гүйцэтгэх Тооцооны ерөнхий гишүүнийг сонгож Төв клирингэд ирүүлнэ.
- (8) Тооцооны эрхгүй гишүүн энэ журмын 6.3(7)-д заасны дагуу төлбөр тооцоо гүйцэтгэх Тооцооны ерөнхий гишүүнийг сонгож Төв клирингэд мэдэгдээгүй тохиолдолд тухайн тооцооны эрхгүй гишүүн өөрийн үндсэн төлбөр тооцоо гүйцэтгэгч Тооцооны ерөнхий гишүүнийг төлбөр тооцоо гүйцэтгүүлэхээр сонгосонд тооцно.

6.4. Хэлцэл бүртгэх

- (1) Төв клиринг нь хэлцлийн бүртгэлийг төвлөрсөн, эсхүл хоёр талт бүртгэлийн загвар ашиглан гүйцэтгэж болно. Төв клиринг үнэт цаасны төрөл, төлбөр тооцоонд оролцогчийн төрлөөс хамаарч харилцан адилгүй бүртгэл хийж болох бөгөөд энэ тухай Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд заасан байна.
- (2) Төв клиринг хоёр талт хэлцлийн бүртгэл хийж байгаа тохиолдолд хэлцлийн талуудыг өөрчлөхгүй бөгөөд анх хэлцэл хийсэн талууд хэвээр бүртгэгдэнэ.
- (3) Төв клиринг төвлөрсөн хэлцлийн бүртгэл хийж байгаа тохиолдолд анх хэлцэл хийсэн талууд өөрчлөгдөх бөгөөд шинээр үүссэн хэлцлийн нэг тал нь Төв клиринг, нөгөө тал нь Тооцооны гишүүн байна.
- (4) Төвлөрсөн хэлцлийн бүртгэл хийгдэж байгаа тохиолдолд аливаа хэлцэл клирингийн системд бүртгэгдмэгц түүнийг Төв клирингтэй байгуулсан 2 хэлцэл болгон бүртгэнэ. Энэ тохиолдолд Төв клиринг нь худалдан авагчийн өмнө худалдагчийн, худалдагчийн өмнө худалдан авагчийн үүрэг хүлээнэ.
- (5) Хэлцэл анх хийсэн худалдагч болон худалдан авагчийн хэлцлийн үүргийг Тооцооны гишүүн Төв клирингийн өмнө хүлээнэ.

6.5. Эмхэтгэл

- (1) Төв клиринг нь төлбөр тооцоо гүйцэтгэх, эрсдэлийн удирдлага, хяналт хэрэгжүүлэх зорилгоор хэлцлийн эмхэтгэл хийж болно.
- (2) Эмхэтгэлийг дараах дараалал, үе шатаар зохион байгуулж болно. Үүнд:
 - (i) Клирингийн данс тус бүрээр;
 - (ii) Клирингийн данс хооронд;
 - (iii) Төлбөр тооцоонд оролцогч тус бүрээр;
 - (iv) Төлбөр тооцоонд оролцогчдын хооронд.
- (3) Хэлцлийг эмхэтгэхдээ энэ журмын 6.5(2)-т зааснаас гадна үнэт цаас тус бүрээр, эсхүл хэд хэдэн үнэт цаасны эмхэтгэлийг нэгтгэн хийж болох бөгөөд энэ тухай Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд заасан байна.
- (4) Тооцооны гишүүн өөрийн нэр дээр нэгээс дээш данстай тохиолдолд Төв клиринг тухайн дансдын хооронд эмхэтгэл хийх, Төв клирингтэй хийх төлбөр тооцоог барагдуулах зорилгоор мөнгөн хөрөнгийг данс хооронд шилжүүлэн ашиглаж болно.
- (5) Дараах баримт бичигт өөрөөр заагаагүй бол Төв клиринг нь тооцооны гишүүн болон түүний харилцагчийн данс хооронд эмхэтгэл хийх, эсхүл позиц шилжүүлэх эрхгүй байна. Үүнд:
 - (i) Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журам
 - (ii) Эрсдэлийн сангийн журам;
 - (iii) Төлбөр тооцоонд оролцогчдын хооронд байгуулсан гэрээ.
- (6) Төв клиринг эмхэтгэл хийсний дүнд төлбөрийн даалгавар боловсруулах бөгөөд төлбөрийн даалгавар нь дараах хэлбэртэй гарч болно. Үүнд:

№	Үнэт цаас	Бэлэн мөнгө	Эмхэтгэлийн үр дүн	Төлбөрийн даалгавар
1	Шилжүүлэх	Хүлээн авах	Энгийн	ТЭН / DvP
2	Хүлээн авах	Шилжүүлэх	Энгийн	НЭТ / RvP
3	Шилжүүлэх	-	Зөвхөн үнэт цаасны гүйлгээ	
4	Хүлээн авах	-	Зөвхөн үнэт цаасны гүйлгээ	
5	Шилжүүлэх	Шилжүүлэх		
6	Хүлээн авах	Хүлээн авах		
7	-	Хүлээн авах	Зөвхөн бэлэн мөнгөн гүйлгээ	
8	-	Шилжүүлэх	Зөвхөн бэлэн мөнгөн гүйлгээ	

6.6. Төлбөр гүйцэтгэх

- (1) Төв клиринг нь эмхэтгэлийн дүнд үүссэн төлбөрийн даалгаврыг холбогдох төлбөр тооцоонд оролцогчид хүргүүлнэ.
- (2) Төлбөр тооцоонд оролцогчид төлбөр тооцоо гүйцэтгэхдээ Төв клирингээс ирүүлсэн төлбөрийн даалгаврыг үндэслэн гүйцэтгэнэ.
- (3) Төв клиринг төлбөр тооцоонд оролцогчийн төлбөрийн үүргийг хангуулах зорилгоор дараах давтамжтай төлбөрийн тооцооллыг хийнэ. Үүнд:
 - (i) Нээлттэй позицын хувьд өдөр бүр;
 - (ii) Хаагдсан позицын хувьд эцсийн тооцоог нэг удаа.
- (4) Нээлттэй позицын хувьд түүний төлбөрийн эрсдэлийг бууруулах зорилгоор Төв клиринг өдөр бүр нээлттэй позицын үнэлгээ хийнэ.
- (5) Нээлттэй позицын үнэлгээ түүний өмнөх өдрийн үнэлгээнээс буурсан тохиолдолд Төв клиринг холбогдох төлбөр тооцоонд оролцогчийн дэнчинг нэмж тусгаарлах буюу түүнээс нэмж дэнчин шаардаж болно.
- (6) Төв клирингийн тооцооллын дүнд үүссэн төлбөрийн үүргийг Төв клирингийн хувьд өөрийн тооцооны гишүүдтэй, тооцооны гишүүдийн хувьд түүний харилцагчидтай хийж гүйцэтгэнэ.
- (7) Тооцооны гишүүн төлбөрийн гүйлгээг өөрийн гэрээт төлбөрийн агентад мэдэгдэл хүргүүлснээр гүйцэтгүүлж болно.
- (8) Төлбөрийн агент нь Хадгаламжийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх эрхтэй тохиолдолд төлбөрийн эсрэг нийлүүлэлт хийх гүйлгээг хийж болно.

ДОЛОО. БУСАД

7.1. Клирингийн систем

- (1) Төв клиринг нь түүний тавьсан шалгуурыг хангасан техник, тоног төхөөрөмж бүхий төлбөр тооцоонд оролцогчийг клирингийн системд холбох ажлыг зохион байгуулна.
- (2) Төлбөр тооцоонд оролцогч нь клирингийн системийн найдвартай ажиллагааг хангах үүднээс Төв клирингээс шаардсан шалгуурыг хангасан техник, тоног төхөөрөмжтэй байна.
- (3) Төв клиринг нь тооцооны гишүүдийн ашиглах клирингийн систем, программ хангамжийн найдвартай ажиллагааг хангахаас гадна клирингийн системд бүртгэгдсэн тооцооны гишүүн болон түүний харилцагчийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.
- (4) Клирингийн системд холбогдсон төлбөр тооцоонд оролцогч Төв клирингийн шалгуурыг хангаагүйгээс үүдэн системд гарсан аливаа доголдлыг Төв клиринг хариуцахгүй.
- (5) Төв клиринг нь клирингийн системд шаардлагатай засвар, шинэчлэл хийх зорилгоор системийг тодорхой хугацаагаар хэсэгчлэн хязгаарлах, эсвэл бүхэлд нь зогсоох эрхтэй байна.
- (6) Төв клиринг нь клирингийн системийг хязгаарлах, эсвэл зогсоох тохиолдолд ажлын тав (5)-аас доошгүй хоногийн өмнө төлбөр тооцоонд оролцогчдод мэдэгдэх бөгөөд мэдэгдэлд системийг хязгаарлах, эсвэл зогсоох болсон шалтгаан, түүний үргэлжлэх хугацаа, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан байна.
- (7) Клирингийн системд доголдол үүссэн, эсхүл шаардлагатай засвар, шинэчлэлт хийж байгаа тохиолдолд төлбөр тооцооны үйл ажиллагааг Төв клирингийн шийдвэрээр гар ажиллагаанд шилжүүлж болно.
- (8) Төлбөр тооцооны үйл ажиллагааг гар ажиллагаанд шилжүүлсэн тохиолдолд Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд хавсаргасан маягтуудыг төлбөр тооцоонд оролцогчдын хооронд байгуулсан гэрээнд заасан албан ёсны хаягаар харилцаа холбооны бусад хэрэгслийг ашиглан солилцох замаар төлбөр тооцооны үйл ажиллагааг явуулна.
- (9) Төлбөр тооцооны үйл ажиллагааг гар ажиллагаанд шилжүүлэх болсон тохиолдолд Төв клиринг энэ тухай төлбөр тооцоонд оролцогчдод урьдчилан мэдэгдэх бөгөөд мэдэгдэлд гар ажиллагааг үргэлжлүүлэх хугацаа болон хэрхэн явуулах зааварчилгааг тусгасан байна.

7.2. Мэдээ, мэдээлэл солилцох

- (1) Төлбөр тооцооны үйл ажиллагаатай холбоотой тайлан мэдээг төлбөр тооцоонд оролцогч нь клирингийн системийг ашиглан солилцох бөгөөд Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд заасан хуваарийн дагуу хэвлэмэл хэлбэрээр үйлдэж хадгална.
- (2) Клирингийн систем дэх аливаа тайлан мэдээг засварлах, эсхүл залруулга хийх тохиолдолд төлбөр тооцоонд оролцогч нь Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд өөрөөр заагаагүй тохиолдолд Төв клирингээс зөвшөөрөл авсан байна.

- (3) Клирингийн систем дэх аливаа тайлан мэдээг Төв клиринг засварлах, эсхүл залруулга хийх тохиолдолд холбогдох талуудад тайлан мэдээ засварласан, эсхүл залруулсан тухай нэн даруй мэдэгдэнэ.
- (4) Төлбөр тооцоонд оролцогч нь аливаа мэдээ, мэдээллийг солилцохдоо клирингийн системд цахим хэлбэрээр, эсхүл гэрээнд заасан хаягаар хэвлэмэл хэлбэрээр солилцож болно.
- (5) Төлбөр тооцоонд оролцогч нь гэрээнд заасан хаяг болон бусад холбогдох мэдээлэл өөрчлөгдсөн тухай бүрт ажлын 3 (гурав)-аас дээшгүй хоногт багтаан Төв клирингэд мэдэгдэнэ.
- (6) Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд төлбөр тооцоонд оролцогчийн төрөл тус бүрээр ирүүлэх мэдээ, мэдээллийн жагсаалт, түүнийг солилцох хэлбэр, хуваарийг тусгасан байна.
- (7) Төв клиринг нь төлбөр тооцоонд оролцогчдод мэдээлэл хүргүүлэхдээ өөрийн цахим хуудсаар дамжуулан хүргэж болох бөгөөд энэ тохиолдолд тухайн мэдээлэл цахим хуудсанд тавигдсан даруйд түүнийг төлбөр тооцоонд оролцогчид мэдэгдсэн гэж үзнэ.
- (8) Аливаа мэдэгдлийг шуудангаар хүргүүлсэн бол шууданд хийснээр, цахим шуудангаар хүргүүлсэн бол цахим шуудан илгээгдсэнээр, факсаар хүргүүлсэн бол нөгөө тал нь хүлээн авсан тухай мэдэгдсэнээр, биечлэн хүргүүлсэн бол энэ тухай баримт үйлдсэнээр мэдэгдэл хүргэгдсэнд тооцно.
- (9) Төв клиринг нь түүний тооцооны гишүүн болон түүнд холбогдох үнэт цаасны арилжааны мэдээллийг дараах этгээдэд гаргаж өгч болно. Үүнд:
 - (i) Тухайн гишүүн, эсхүл түүний холбогдох харилцагч;
 - (ii) Төв клирингээс энд дурдсан мэдээллийг хуулийн дагуу шаардах эрхтэй эрх бүхий байгууллага;
 - (iii) Үнэт цаасны хөдөлгөөнтэй холбоотой тохиолдолд Төв клирингтэй гэрээ байгуулсан үнэт цаасны хадгаламжийн байгууллага;
 - (iv) Мөнгөн хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой тохиолдолд төлбөр гүйцэтгэгч банк, эсхүл төлбөрийн агент;
 - (v) Төв клирингээс энд дурдсан мэдээг өгөхөөр тохиролцож гэрээ байгуулсан бусад этгээд;
 - (vi) Төв клирингээс шаардлагатай гэж үзсэн бусад.

7.3. Шимтгэл, хураамж

- (1) Төв клиринг энэ журмын [Хавсралт 3](#)-т заасан хувь хэмжээгээр үйлчилгээний хөлс, шимтгэл, хураамж авах бөгөөд тухайн хувь хэмжээ өөрчлөгдсөн тухай бүрт түүнийг мөрдөж эхлэх өдрөөс 30 (гуч)-аас доошгүй хоногийн өмнө нийт төлбөр тооцоонд оролцогчдод мэдэгдэнэ.
- (2) Төв клиринг нь тооцооны гишүүдээс авах үйлчилгээний хөлс, шимтгэл, хураамжийг нэхэмжлэхдээ клирингийн систем болон түүний цахим хаяг, эсхүл гэрээнд заасан хаягаар хүргүүлж болох бөгөөд тооцооны гишүүн тухайн нэхэмжлэхэд заасан дүнг заасан хугацаанд багтан төлөх үүрэгтэй.
- (3) Тооцооны гишүүн нь тооцооны эрхгүй гишүүн, өөрийн харилцагчаас авах үйлчилгээний хөлс, шимтгэл, хураамжийн хувь, хэмжээг тогтоох бөгөөд Төв

клирингээс тооцооны гишүүний авч болох үйлчилгээний хөлс, шимтгэл, хураамжийн дээд хувь, хэмжээг тогтооно.

- (4) Тооцооны гишүүн нь өөрийн харилцагч тооцооны эрхгүй гишүүнээс авах үйлчилгээний хөлс, шимтгэл хураамжийн хэмжээг нэгдсэн байдлаар өөрийн дотоод журамд, эсхүл тухайн тооцооны эрхгүй гишүүнтэй байгуулсан гэрээнд тодорхой тусгасан байна.
- (5) Тооцооны гишүүн нь өөрийн харилцагч тооцооны эрхгүй гишүүн болон түүний харилцагчаас дараах шимтгэл хураамжийг авч болно. Үүнд:
 - (i) Төлбөр тооцооны шимтгэл;
 - (ii) Клирингийн данс нээсний хураамж;
 - (iii) Клирингийн дансны бүртгэлийн хураамж;
 - (iv) Төв клирингээс зөвшөөрсөн бусад.
- (6) Тооцооны гишүүн энэ журмын 7.3(5)-д заасан шимтгэл хураамжаас гадна дэнчин болон үнэт цаас зээлдүүлэх, репо хэлцэл хийх үнийн дүнгээс хүү тооцож авч болно. Тооцооны гишүүн өөрийн авах хүүгийн хэмжээг өөрийн харилцагчтай хийсэн гэрээнд тодорхой заасан байна.
- (7) Тооцооны гишүүн харилцагчийн нийт төлбөрийн гүйлгээний үнийн дүнгээс хувиар тооцож шимтгэл авна.
- (8) Энэхүү журмын 7.3(5)-ын (i)-д заасан төлбөр тооцооны шимтгэл гэж төлбөр тооцооны эрхгүй этгээдэд төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлсэн, түүний нэрийн өмнөөс Төв клирингийн өмнө харилцагчийн нэрийн өмнөөс үүрэг биелүүлсний дүнд авах шимтгэл байна.
- (9) Энэхүү журмын 7.3(5)-ын (ii)-д заасан клирингийн данс нээсний хураамж гэж тооцооны гишүүн нь тооцооны эрхгүй этгээдийн төлбөр тооцооны бүртгэлийг хөтлөх клирингийн данс нээсний дүнд авах шимтгэлийг хэлнэ. Клирингийн данс нээсний хураамжийг тухайн этгээдтэй гэрээ байгуулсан даруйд 1 (нэг) удаа авна.
- (10) Энэхүү журмын 7.3(5)-ын (iii)-д заасан клирингийн дансны бүртгэлийн хураамжийг клирингийн дансны тооцооны тооноос хамааруулан сар бүр тогтмол дүнгээр тооцож авч болно.
- (11) Төв клиринг энэ журмын [Хавсралт 3](#)-т заасан шимтгэл хураамжаас төлбөр тооцоонд оролцогчийг чөлөөлж болох бөгөөд энэ тохиолдолд шимтгэл, хураамжаас чөлөөлөх нөхцөл, түүнийг хэрэгжүүлэх хэлбэрийг Төв клирингийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тухай бүр тусгана.

7.4. Гэрээний үүрэг биелүүлэхгүй байх буюу төлбөрийн чадваргүй болох

- (1) Дараах тохиолдолд төлбөр тооцоонд оролцогчийг үнэт цаасны арилжааны гэрээний үүргээ биелүүлээгүй гэж үзнэ. Үүнд:
 - (i) Тооцооны гишүүн болон тооцооны эрхгүй гишүүн нь Төв клирингтэй байгуулсан аливаа гэрээний заалтыг зөрчсөн, энэхүү журмыг дагаж мөрдөөгүйгээс хохирол учирч, Төв клирингээс тухайн этгээдийг өөрийн үүргээ биелүүлээгүй гэж үзсэн бол;
 - (ii) Төлбөр тооцоонд оролцогч Биржийн журмыг дагаж мөрдөөгүй нь тогтоогдож, арилжаанд оролцох эрхгүй болсон бол;

- (iii) Төлбөр тооцоонд оролцогч тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан, дампуурсан зэргээс шалтгаалан үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон бол;
 - (iv) Төв клирингээс ирүүлсэн аливаа нэхэмжлэхэд заасан үнэт цаас, бэлэн мөнгө болон бусад хөрөнгийг заасан хугацаанд төлж барагдуулаагүй буюу төлбөрийн чадваргүй болсон бол;
 - (v) Эрсдэлийн сангийн журамд заасан бусад.
- (2) Энэхүү журмын 7.4(1)-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд Төв клиринг үүссэн нөхцөл байдлыг зохицуулах үүрэгтэй бөгөөд энэ журам болон бусад холбогдох журамд заасны дагуу арга хэмжээ авна.
- (3) Төлбөр тооцоонд оролцогч үнэт цаасны арилжааны гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд Төв клиринг дараах арга хэмжээ авна. Үүнд:
- (i) Гэрээний үүргээ биелүүлээгүй төлбөр тооцоонд оролцогчийн нээлттэй позицыг хаах, эсхүл бусад төлбөр тооцоонд оролцогчид шилжүүлэх;
 - (ii) Гэрээний үүргээ биелүүлээгүй төлбөр тооцоонд оролцогчийн учруулсан хохирлыг барагдуулах зорилгоор түүний дэнчин, барьцаа болон бусад хөрөнгөөс суутгах, шаардлагатай тохиолдолд үнэт цаас зэрэг худалдаж болох хөрөнгийг худалдах;
 - (iii) Гэрээний үүргээ биелүүлээгүй Төлбөр тооцоонд оролцогчийн зөвшөөрөлтэй эсэхээс үл хамааран түүний клирингийн данснаас зарлагын гүйлгээ хийх;
 - (iv) Бусад төлбөр тооцоонд оролцогчийг хамгаалах зорилгоор зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж Төв клирингийн үзсэн бусад.
- (4) Энэ журмын 7.4(3)-т заасан нэг буюу хэд хэдэн арга хэмжээг Төв клиринг авч хэрэгжүүлэх болсон тохиолдолд холбогдох төлбөр тооцоонд оролцогчийг үнэт цаасны арилжааны гэрээний үүргээ биелүүлээгүй гэж үзнэ.
- (5) Төлбөр тооцоонд оролцогч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд Төв клиринг энэ тухай нийт төлбөр тооцоонд оролцогчдод нэн даруй мэдэгдэнэ.
- (6) Төлбөр тооцоонд оролцогч Биржийн арилжаатай холбогдон үүссэн үүргээ биелүүлээгүйгээс дефолт болсон бол Төв клиринг түүний дэнчин, барьцаа болон бусад хөрөнгийг учирсан хохирлыг барагдуулахад ашиглах бүрэн эрхтэй.
- (7) Төлбөр тооцоонд оролцогч нь Төв клирингийн гишүүн байх тохиолдолд түүнийг дефолт болсон гэж Төв клиринг зарласан нь тухайн төлбөр тооцоонд оролцогчийн гишүүнчлэлийн эрхийг түдгэлзүүлэх үндэслэл болно.
- (8) Дефолт болсон төлбөр тооцоонд оролцогчийн учруулсан хохирлыг барагдуулсны дараа тухайн оролцогчид харгалзах үлдсэн хөрөнгийг тухайн төлбөр тооцоонд оролцогч буцаан авах эрхтэй.

7.5. Зөрчил, хариуцлага

- (1) Төв клиринг дараах тохиолдолд тооцооны гишүүнийг зөрчил гаргасан гэж үзнэ. Үүнд:
- (i) Биржийн болон биржийн бус арилжаагаар хүлээсэн гэрээний үүргээ биелүүлээгүй;
 - (ii) Биржийн болон биржийн бус хэлцлийн төлбөрийг заасан хугацаанд төлөөгүй;

- (iii) Төв клирингээс нэхэмжилсэн шимтгэл, хураамжийг заасан хугацаанд төлөөгүй;
 - (iv) Төв клирингийн болон бусад төлбөр тооцоонд оролцогчийн нэр хүндэд халдсан;
 - (v) Өөрийн харилцагчийг төөрөгдүүлэх зэргээр гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй;
 - (vi) Төлбөр тооцоотой холбоотой хуурамч бичиг баримт бүрдүүлсэн;
 - (vii) Төв клирингээс зөрчил гэж үзсэн бусад.
- (2) Төлбөр тооцоонд оролцогч нь холбогдох хууль тогтоомж, Төв клирингийн болон Биржийн дүрэм журам, гэрээний заалтыг зөрчсөн тохиолдолд Төв клиринг дараах арга хэмжээг авч болно. Үүнд:
- (i) Зөрчил гаргасан этгээдэд зөрчил гаргасан тухай мэдэгдэх, тухайн зөрчлөөс хамаарч 30-аас дээшгүй хоногийн хугацаанд гаргасан зөрчлөө арилгах тухай сануулах;
 - (ii) Зөрчил гаргасан этгээдийн учруулсан хохирол нь бусад төлбөр тооцоонд оролцогчдод хамааралтай тохиолдолд тэдгээр оролцогчдод мэдэгдэх;
 - (iii) Зөрчил гаргасан этгээд нь заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй тохиолдолд түүний төлбөр тооцоо хийх эрхийг хязгаарлах, эсхүл гишүүнчлэлийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх;
 - (iv) Зөрчил гаргасан этгээд түүний гишүүнчлэлийг түдгэлзүүлсэн, эсхүл төлбөр тооцоо хийх эрхийг хязгаарласан хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд тухайн асуудлыг ТУЗ-д танилцуулж, гишүүнчлэлийг цуцлах тухай санал оруулах;
 - (v) Эрх бүхий байгууллагад мэдэгдэх, түүнээс гаргасан шийдвэрийг олон нийтэд мэдээлэх;
 - (vi) Төв клирингийн болон Биржийн холбогдох дүрэм журамд заасан бусад.
- (3) Тооцооны гишүүний төлбөр тооцоо хийх эрхийг, эсхүл гишүүнчлэлийг түдгэлзүүлсэн бол энэ тухай мэдэгдлийг Төв клиринг өөрийн цахим хуудсанд байршуулж нийт төлбөр тооцоонд оролцогчдод мэдэгдэнэ.
- (4) Төв клирингээс нэхэмжилсэн дүнг төлбөр тооцоонд оролцогч заасан хугацаанд төлж барагдуулаагүй тохиолдолд Төв клиринг алданги тооцож авах бөгөөд алданги тооцох хувийг Төв клиринг баталж, нийт төлбөр тооцоонд оролцогчдод мэдэгдэнэ.
- (5) Төлбөр тооцоонд оролцогч нь хууль тогтоомж, Төв клирингийн болон Биржийн дүрэм журам, гэрээний заалтыг зөрчсөнөөс үүдэн гарсан аливаа хохирлыг буруутай этгээд бүрэн хариуцна.

7.6. Маргаан шийдвэрлэх

- (1) Энэхүү журамтай холбоотой аливаа маргаан үүссэн тохиолдолд Бирж болон Төв клирингийн холбогдох журам, төлбөр тооцоонд оролцогчдын хооронд байгуулсан гэрээнд заасны дагуу шийдвэрлэнэ.

7.7. Давагдашгүй хүчин зүйл

- (1) Давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан төлбөр тооцооны үйл ажиллагааг хэвийн явуулах боломжгүй болсон тохиолдолд Төв клиринг болон тооцооны гишүүд хариуцлага хүлээхгүй.
- (2) Давагдашгүй хүчин зүйл гэдэгт дараах үйл явдлыг хамруулан авч үзнэ. Үүнд:
 - (i) Зарласан буюу зарлаагүй дайн, байлдаан, зэвсэгт мөргөлдөөн, үймээн самуун, хувьсгал, бослого, иргэний эмх замбараагүй байдал гэх мэт;
 - (ii) Төв клиринг, эсхүл бусад төлбөр тооцоонд оролцогчдын төлбөр тооцооны үйл ажиллагаанд оролцоход шаардлагатай тусгай зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас хүчингүй болгосон;
 - (iii) Газар хөдлөлт, үер, гал түймэр, бүх нийтийг хамарсан гоц халдварт өвчин зэргээс шалтгаалан онц байдал зарласан.
- (3) Энэ журмын 7.7(2)-т заасан нөхцөл байдал үүссэн, эсхүл Төв клиринг онцгой нөхцөл байдал үүссэн гэж үзсэн бол дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:
 - (i) Онцгой нөхцөл байдал үүссэн тухай нийт төлбөр тооцоонд оролцогчдод мэдэгдэх;
 - (ii) Онцгой нөхцөл байдал үүсч, төлбөр тооцооны үйл ажиллагааг хэвийн явуулах боломжгүй нь тогтоогдсон даруйд төлбөр тооцооны үйл ажиллагааг зогсоох;
 - (iii) Онцгой нөхцөл байдал үүссэнтэй холбогдон гарсан аливаа доголдлыг цаг алдалгүй засварлах, учрах хохирлыг хамгийн бага байлгахын тулд шаардлагатай бүх арга хэмжээ авах;
 - (iv) Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд заасан бусад.